



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/327

Номгон

Байгалийн горим эвдэгдсэн, бохирдсон голуудын
гольдролд үзлэг хийж, эвдэгдсэн хэсэгт гольдрол
шулуутган далан байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4."в", 29.1.6."а", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Усны хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/8 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 125, Байгаль орчин аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах 21-03 гэрээний 1 дүгээр хавсралтын 25, 28 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Богд, Жинст, Өлзийт, Баянхонгор, Эрдэнэцогт, Заг, Жаргалант, Бөмбөгөр, Бууцагаан сумдын нутаг дэвсгэрээр урсах Түй, Байдраг голуудын үндсэн гольдролд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, Орог нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Богд сумын нутагт Хориулт орчмын газарт усны алдагдлыг бууруулах далан барьж байгуулах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Түй, Байдраг голуудын үндсэн гольдролд үзлэг шалгалт хийхэд шаардагдах 2,000,000 (хоёр сая), далан барьж байгуулахад шаардагдах 8.000.000 (найман сая) төгрөгийг Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын хэсгийг 3 дугаар улиралд багтаан орон нутагт ажиллуулж голуудын гольдролд үзлэг хийж, эвдэгдсэн газруудын талбайг тогтоох, Богд сумын Хориулт орчмын усны алдагдлыг бууруулж далан хаалт байгуулах ажлыг зохион байгуулж тайланг 4 дүгээр улиралд багтааж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хүрэлсүх)-д үүрэг болгосугай.


621010831

2.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын
21-ний өдрийн А/327 дугаар захирамжийн 1 дүгээр
хэсрэлт



ТҮЙ, БАЙДРАГ ГОЛУУДЫН ҮНДСЭН ГОЛБДРОЛД
ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч Э.Ганзориг -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Намуун -Аймгийн Засаг даргын тамгын газрын Байгаль орчин
, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

Г.Нансалмаа -Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны ахлах
мэргэжилтэн


Э. Жамц -Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны мэргэжилтэн

Сумдын засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Газрын
даамал, Хариуцсан хэсгийн Байгаль хамгаалагч нар

Нарийн бичгийн дарга Г.Хүрэлсүх-Бөөнцагаан-Орог нуурын сав газрын
захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

оОо

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын
21-ний өдрийн А/327 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт



**БОГД СУМЫН НУТАГТ ХОРИУЛТ ОРЧМЫН ГАЗАРТ УСНЫ
АЛДАГДЛЫГ БУУРУУЛАХ ДАЛАН БАРЬЖ БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч Г.Хүрэлсүх - Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Д.Өлзийбаяр -Богд сумын Засаг дарга

Б.Зүгдоржав -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал, төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

Г.Нансалмаа -Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн

Э.Жамц -Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны мэргэжилтэн

Д.Ганзориг -Богд сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

С.Баянмөнх -Түй Богдын харуул

Ц.Рагчаа -Орог нуурын харуул

Нарийн бичгийн дарга: Б.Намуун -Аймгийн Засаг даргын тамгын газрын Байгаль орчин ,аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

_____оОо_____